



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/360/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Албан шаардлага	19
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/419
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 382,090.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	335,566,325.96	554,912,366.96
33	АВЛАГА	0.00	289,972,305.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	289,972,305.00
35	БАРАА МАТЕРИАЛ	335,566,325.96	264,940,061.96
35400	Хангамжийн материал	335,566,325.96	264,940,061.96
35410	Бичиг хэргийн материал	21,619,609.00	29,795,244.00
35420	Аж ахуйн материал	199,181,103.96	170,603,254.96
35430	Сэлбэг хэрэгсэл	42,494,200.00	47,721,900.00
35440	Түлш, шатах тослох материал	10,235,000.00	11,745,000.00
35470	Бусад хангамжийн материал	62,036,413.00	5,074,663.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,133,307,852.03	12,525,142,715.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,133,307,852.03	12,525,142,715.36
39200	Биет хөрөнгө	9,153,793,865.46	10,582,053,728.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,061,510,507.50	9,061,510,507.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(444,653,222.37)	(658,387,145.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,178,647,200.00	1,240,647,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,156,869,422.16)	(1,175,269,422.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,690,534,612.38	3,403,988,695.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,494,286,613.14)	(1,729,000,784.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	730,023,770.58	920,052,242.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(483,077,753.96)	(550,567,810.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,867,200.00	50,867,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(39,375,740.49)	(42,260,281.65)
39217	Ном	60,473,327.12	60,473,327.12
39300	Биет бус хөрөнгө	1,979,513,986.57	1,943,088,986.53
39301	Программ хангамж	346,005,390.00	346,005,390.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(253,976,223.43)	(290,401,223.47)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,887,484,820.00	1,887,484,820.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,468,874,177.99	13,080,055,082.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,468,874,177.99	13,080,055,082.32
51	Засгийн газрын хувь оролцоо	11,468,874,177.99	13,080,055,082.32
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,646,495,144.95	2,646,495,144.95
51101	Өмч: -төрийн	759,010,324.95	759,010,324.95
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,887,484,820.00	1,887,484,820.00
51200	Хуримтлагдсан үр дүн	6,178,075,046.37	7,789,255,950.70
51210	Өмнөх үеийн үр дүн	6,403,154,468.74	6,178,075,046.37
51220	Тайлант үеийн үр дүн	(225,079,422.37)	1,611,180,904.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,644,303,986.67	2,644,303,986.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,468,874,177.99	13,080,055,082.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,397,894,427.98	5,711,085,374.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	281,907,699.98	1,918,068,413.97
120	Нийтлэг татварын бус орлого	281,907,699.98	430,717,413.97
120004	Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого	272,183,700.00	163,194,026.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	272,183,700.00	163,194,026.97
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	9,423,999.98	266,558,387.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	300,000.00	965,000.00
122	Тусламжийн орлого	0.00	1,487,351,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	11,491,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	0.00	1,475,860,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,115,986,728.00	3,793,016,960.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,984,914,544.00	3,268,065,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,984,914,544.00	3,268,065,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,072,184.00	524,951,060.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,098,529.00	299,138,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	121,973,655.00	225,812,906.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,518,921,110.35	3,996,470,887.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,518,921,110.35	3,996,470,887.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,259,002,461.31	3,595,753,825.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,719,544,476.19	1,824,080,846.59
210101	Үндсэн цалин	1,238,723,576.19	1,296,904,511.71
210102	Нэмэгдэл	280,970,200.00	281,408,326.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	128,636,000.00	128,978,557.42
210104	Урамшуулал	71,214,700.00	116,789,451.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,945,530.22	239,949,000.97
210201	Тэтгэврийн даатгал	155,776,733.63	169,560,512.24
210202	Тэтгэмжийн даатгал	17,112,958.76	17,994,412.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,693,501.06	14,106,569.83
210204	Ажилгүйдлийн даатгал	4,447,955.77	3,480,682.35
210205	Эрүүл мэндийн даатгал	32,914,381.00	34,806,824.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,903,854.08	215,962,985.06
210301	Гэрэл, цахилгаан	48,689,163.47	41,195,721.54
210302	Түлш, халаалт	9,638,148.61	10,247,346.30
210303	Цэвэр, бохир ус	4,661,552.00	5,604,927.22
210304	Байрны түрээс	128,914,990.00	158,914,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	263,430,492.39	311,625,081.05
210401	Бичиг хэрэг	42,290,285.92	49,092,550.00
210402	Тээвэр, шатахуун	51,357,000.00	42,149,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	73,273,485.47	78,802,377.05
210404	Ном, хэвлэл	35,075,060.00	40,045,188.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,181,500.00	1,032,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,253,161.00	70,248,692.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	30,254,674.00
2105	Нормативт зардал	962,000.00	2,061,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	962,000.00	2,061,200.00

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,689,670.00	128,464,993.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,520,300.00	12,391,700.00
210604	Урсгал засвар	21,169,370.00	116,073,293.00
2107	Томилолт, зочны зардал	24,898,100.00	29,002,300.00
210702	Дотоод албан томилолт	18,047,300.00	20,952,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,850,800.00	8,050,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,979,266.00	202,148,085.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,771,623.00	134,388,666.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	7,832,025.00	6,136,860.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,053,452.00	1,773,909.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	570,000.00	465,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,840,800.00	45,008,650.00
210807	Газрын төлбөр	8,911,366.00	14,375,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	681,649,072.43	642,459,333.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,940,000.00	0.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	113,205,478.00	68,811,642.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	444,503,594.43	573,647,691.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	259,918,649.04	400,717,062.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,866,277.00	220,183,769.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,147,133.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,074,144.00	58,960,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,645,000.00	161,223,769.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	142,052,372.04	180,533,293.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,052,372.04	180,447,205.30
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг – нэмэлт	0.00	86,088.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(121,026,682.37)	1,714,614,486.33
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	104,052,740.00	103,433,582.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	104,052,740.00	103,433,582.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(225,079,422.37)	1,611,180,904.33

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,403,154,468.74	11,693,953,600.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,403,154,468.74	11,693,953,600.36
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(225,079,422.37)	(225,079,422.37)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,178,075,046.37	11,468,874,177.99
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,178,075,046.37	11,468,874,177.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	6,178,075,046.37	11,468,874,177.99
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,611,180,904.33	1,611,180,904.33
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,789,255,950.70	13,080,055,082.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,391,632,999.00	3,956,210,987.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	275,646,271.00	163,194,026.97
120	Нийтлэг татварын бус орлого	275,646,271.00	163,194,026.97
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	275,646,271.00	163,194,026.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	275,646,271.00	163,194,026.97
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,115,986,728.00	3,793,016,960.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,984,914,544.00	3,268,065,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,984,914,544.00	3,268,065,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,072,184.00	524,951,060.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,098,529.00	299,138,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	121,973,655.00	225,812,906.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	3,254,570,115.00	3,744,637,818.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,254,570,115.00	3,744,637,818.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,994,651,465.96	3,053,948,451.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,719,544,476.19	1,824,080,846.59
210101	Үндсэн цалин	1,238,723,576.19	1,296,904,511.71
210102	Нэмэгдэл	280,970,200.00	281,408,326.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	128,636,000.00	128,978,557.42
210104	Урамшуулал	71,214,700.00	116,789,451.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,945,530.22	239,949,000.97
210201	Тэтгэврийн даатгал	155,776,733.63	169,560,512.24
210202	Тэтгэмжийн даатгал	17,112,958.76	17,994,412.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,693,501.06	14,106,569.83
210204	Ажилгүйдлийн даатгал	4,447,955.77	3,480,682.35
210205	Эрүүл мэндийн даатгал	32,914,381.00	34,806,824.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,903,854.08	215,962,985.06
210301	Гэрэл, цахилгаан	48,689,163.47	41,195,721.54
210302	Түлш, халаалт	9,638,148.61	10,247,346.30
210303	Цэвэр, бохир ус	4,661,552.00	5,604,927.22
210304	Байрны түрээс	128,914,990.00	158,914,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	273,658,247.47	278,169,596.05
210401	Бичиг хэрэг	41,068,620.00	49,987,025.00
210402	Тээвэр, шатахуун	43,753,000.00	43,659,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	73,273,485.47	78,802,377.05
210404	Ном, хэвлэл	53,524,600.00	50,316,420.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,181,500.00	1,032,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,857,042.00	54,372,174.00
2105	Нормативт зардал	3,642,000.00	2,479,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,642,000.00	2,479,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,733,675.00	156,316,303.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,821,455.00	37,795,710.00
210602	Тавилга	40,365,150.00	3,234,000.00
210604	Урсгал засвар	28,547,070.00	115,286,593.00
2107	Томилолт, зочны зардал	30,809,800.00	40,464,900.00
210702	Дотоод албан томилолт	20,809,800.00	20,952,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,000,000.00	19,512,900.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205,268,266.00	219,946,085.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,786,623.00	141,098,666.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,832,025.00	6,136,860.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,053,452.00	1,773,909.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	570,000.00	465,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	84,114,800.00	56,096,650.00
210807	Газрын төлбөр	8,911,366.00	14,375,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	237,145,617.00	76,579,535.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,940,000.00	7,608,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	113,205,617.00	68,971,035.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	259,918,649.04	690,689,367.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,866,277.00	220,183,769.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,147,133.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,074,144.00	58,960,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	72,645,000.00	161,223,769.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	142,052,372.04	470,505,598.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,052,372.04	180,447,205.30
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг - нэмэлт	0.00	290,058,393.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	137,062,884.00	211,573,168.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	137,062,884.00	211,573,168.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	137,062,884.00	211,573,168.30
2200	Дотоод эх үүсвэрээр	137,062,884.00	211,573,168.30
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	137,062,884.00	211,573,168.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(137,062,884.00)	(211,573,168.30)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,397,565,900.00	3,250,812,721.67	146,753,178.33	95.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,397,565,900.00	3,250,812,721.67	146,753,178.33	95.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,292,305,900.00	3,145,578,952.67	146,726,947.33	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,855,412,100.00	1,815,983,266.59	39,428,833.41	97.9
210101	Үндсэн цалин	1,359,597,100.00	1,288,806,931.71	70,790,168.29	94.8
210102	Нэмэгдэл	287,484,200.00	281,408,326.46	6,075,873.54	97.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	137,116,100.00	128,978,557.42	8,137,542.58	94.1
210104	Урамшуулал	71,214,700.00	116,789,451.00	(45,574,751.00)	164.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,700,400.00	238,880,731.97	8,819,668.03	96.4
210201	Тэтгэврийн даатгал	178,344,800.00	168,492,243.24	9,852,556.76	94.5
210202	Тэтгэмжийн даатгал	17,339,100.00	17,994,412.11	(655,312.11)	103.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,284,100.00	14,106,569.83	(8,822,469.83)	267.0
210204	Ажилгүйдлийн даатгал	12,054,500.00	3,480,682.35	8,573,817.65	28.9
210205	Эрүүл мэндийн даатгал	34,677,900.00	34,806,824.44	(128,924.44)	100.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,466,300.00	215,962,985.06	9,503,314.94	95.8
210301	Гэрэл, цахилгаан	53,748,300.00	41,195,721.54	12,552,578.46	76.6
210302	Түлш, халаалт	7,514,000.00	10,247,346.30	(2,733,346.30)	136.4
210303	Цэвэр, бохир ус	5,287,900.00	5,604,927.22	(317,027.22)	106.0
210304	Байрны түрээс	158,916,100.00	158,914,990.00	1,110.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	278,427,900.00	278,169,596.05	258,303.95	99.9
210401	Бичиг хэрэг	50,000,000.00	49,987,025.00	12,975.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	43,762,000.00	43,659,600.00	102,400.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	78,200,000.00	78,802,377.05	(602,377.05)	100.8
210404	Ном, хэвлэл	49,940,500.00	50,316,420.00	(375,920.00)	100.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,100,000.00	1,032,000.00	1,068,000.00	49.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,425,400.00	54,372,174.00	53,226.00	99.9
2105	Нормативт зардал	2,500,000.00	2,479,200.00	20,800.00	99.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,479,200.00	20,800.00	99.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	278,873,800.00	276,625,553.00	2,248,247.00	99.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	90,869,000.00	90,675,200.00	193,800.00	99.8
210602	Тавилга	72,600,000.00	70,663,760.00	1,936,240.00	97.3
210604	Урсгал засвар	115,404,800.00	115,286,593.00	118,207.00	99.9
2107	Томиллолт, зочны зардал	22,834,400.00	20,952,000.00	1,882,400.00	91.8
210702	Дотоод албан томиллолт	22,834,400.00	20,952,000.00	1,882,400.00	91.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,858,400.00	219,946,085.00	74,912,315.00	74.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,851,500.00	141,098,666.00	65,752,834.00	68.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,286,600.00	0	3,286,600.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	8,720,500.00	6,136,860.00	2,583,640.00	70.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,524,800.00	1,773,909.00	2,750,891.00	39.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	600,000.00	465,000.00	135,000.00	77.5

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,500,000.00	56,096,650.00	403,350.00	99.3
210807	Газрын төлбөр	14,375,000.00	14,375,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,232,600.00	76,579,535.00	9,653,065.00	88.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,608,500.00	391,500.00	95.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,232,600.00	68,971,035.00	9,261,565.00	88.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,260,000.00	105,233,769.00	26,231.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,260,000.00	105,233,769.00	26,231.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,960,000.00	58,960,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,300,000.00	46,273,769.00	26,231.00	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,397,565,900.00	3,250,812,721.67	146,753,178.33	95.7
35	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,277,565,900.00	3,087,618,694.70	189,947,205.30	94.2
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,277,565,900.00	3,087,618,694.70	189,947,205.30	94.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120,000,000.00	163,194,026.97	(43,194,026.97)	136.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	163,194,026.97	(43,194,026.97)	136.0
	Тохируулгын өөрчлөлт		0.00		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	117	105	12	89.7
620001	Удирдах ажилтан	20	20	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	79	66	13	87.3
620003	Үйлчлэх ажилтан	18	18	0	100.0
620004	Гэрээт ажилтан	0	1	-1	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		524,951,060.30
УРСГАЛ ЗАРДАЛ		524,951,060.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		119,942,667.30
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		8,097,580.00
Үндсэн цалин		8,097,580.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,068,269.00
Тэтгэврийн даатгал		1,068,269.00
Эд хогшил, урсгал засварын зардал		91,263,918.30
Багаж, техник, хэрэгсэл		33,350,006.30
Тавилга		57,913,912.00
Томилолт, зочны зардал		19,512,900.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		19,512,900.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		405,008,393.00
Бусад урсгал шилжүүлэг		114,950,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		114,950,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		290,058,393.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		290,058,393.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		524,951,060.30
Нэмэлт санхүүжилтийн орлого		524,951,060.30
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		299,138,154.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		225,812,906.30

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгө бараа материалын тайлан бэлтгэх, хөрөнгийг ангиллын дагуу бүртгэж байх, батлагдсан төсөв, нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах, шатахуун зарцуулалтын тооцоотой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Ц.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/76 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нь шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Тайлант онд Шүүгчийн хараат бус шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх зорилтын хүрээнд 28 зорилго, 69 зорилт, 258 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” болно.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас анхан болон давж заалдах шатны 25 шүүхийн тамгын газрын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд дотоод аудит хийх, Шилэн дансны тухай хууль, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Ажлын албанаас гаргасан тодорхой дүрэм, журам, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийх, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 83.5 хувийн хэрэгжилттэй байна.

Нийт 24 шүүхийн тамгын газарт хяналт-шинжилгээ хийснээс 21 шүүхийн тамгын газарт зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан. Тайлант онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайлан хяналт-шинжилгээнд хамрагдаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,518,921.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 35,189.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,611,180.9 мянган төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Авлага	0.0	289,972.3	289,972.3
Бараа материал	335,566.3	264,940.1	(70,626.3)
Үндсэн хөрөнгө	11,133,307.9	12,525,142.7	1,391,834.9
Нийт хөрөнгийн дүн	11,468,874.2	13,080,055.1	1,611,180.9
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,468,874.2	13,080,055.1	1,611,180.9
Засгийн газрын оролцоо	11,468,874.2	13,080,055.1	1,611,180.9
Засгийн газрын оруулсан капитал	2,646,495.1	2,646,495.1	0.0
Хуримтлагдсан үр дүн	6,178,075.0	7,789,256.0	1,611,180.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,644,304.0	2,644,304.0	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр өмчийн дүн	11,468,874.2	13,080,055.1	1,611,180.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Германы хамтын ажиллагааны нийгэмлэг олон улсын байгууллагын санхүүжилтээр шүүхийн захиргааны ажилчдад явуулах сургалт хойшлогдсоноос татаас санхүүжилтийн авлага үүссэн;
- Бараа материал дансны үлдэгдэл 264,940.1 мянган төгрөг болж, 70,626.3 мянган төгрөг буюу 21.0 хувиар буурсан нь дүүрэг, орон нутаг дахь шүүхийн тамгын газруудад 102,468.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж, 30,254.7 мянган төгрөгийн бараа материал акталж устгасан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 12,525,142.7 мянган төгрөг болж, 1,391,834.9 мянган төгрөг буюу 12.5 хувиар өссөн нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэг олон улсын байгууллагаас 1,475,760.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар хүлээн авсан, дээд шатны байгууллагаас 266,558.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь тус тус голлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нь 2021 оны төсвийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэрийг 4,102,620.6 мянган төгрөг, үүнээс 4,042,620.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 60,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тооцож, урсгал зардлыг нийт 4,102,620.6 мянган төгрөгөөр төлөвлөж, төсвийн саналыг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт зардлыг 705,054.7 мянган төгрөгөөр бууруулж, 3,397,565.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тухайлбал, бараа ажил үйлчилгээний зардлыг 333,179.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 144,638.7 мянган төгрөг, цалингийн зардлыг 138,725.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 91,842.6 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 62,283.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж, эд хогшил, урсгал засварын зардлыг 74,630.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд зориулан 3,397,565.9 мянган төгрөгийг урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталжээ. Үүнээс 3,277,565.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 120,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,268,065.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 163,194.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 3,250,812.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, үлдэгдэл 180,447.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,250,812.7 мянган төгрөг буюу 95.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 74,912.3 мянган төгрөг, цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэл 48,248.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 9,653.1 мянган төгрөг, бусад зардал 13,939.3 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70701	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах	3,397,565.9	3,250,812.7	146,753.2	95.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,149,864.7	3,068,125.8	81,738.9	97.4
1.2	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	50,840.0	20,380.0	30,460.0	40.1
1.3	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	81,501.2	47,351.4	34,149.8	58.1
1.4	80228	Цахим хуудасны бүртгэлийн хураамж	10,100.0	9,721.8	378.2	96.3
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	105,260.0	105,233.8	26.2	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Германы хамтын ажиллагааны нийгэмлэг олон улсын байгууллагаас 289,972.3 мянган төгрөг, давсан орлого 225,812.9 мянган төгрөг, бусад орлого 9,165.8 мянган төгрөг, нийт 524,951.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 114,950.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 91,263.9 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 19,512.9 мянган төгрөг, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 9,165.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 290,058.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан “ТЕЗ нарын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний тоо болон чанарын үзүүлэлт батлагдаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу авсан судалгаанд анхаарал татсан асуудал гараагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан байна. НБББББ нь байгууллагын нийтлэг зориулалттай санхүүгийн тайланд тавигдах шаардлагыг боловсронгуй болгож, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газруудыг нягтлан бодох бүртгэлийн ижил арга, аргачлал, бодлогоор санхүүгийн тайлан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэхүйц боловсруулагдсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 16 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нь нийт 5,761,624.3 мянган төгрөгийн 296 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,930,735.5 мянган төгрөгийн 175 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Туслах үйл ажиллагааны болон хандив тусламжийн орлоготой холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ТЕЗ-аас бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр туслах үйл ажиллагааны орлого болох тендерийн тодорхойлолт, архивын үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 389,006.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.
- ТЕЗ-аараа дамжуулалгүйгээр хандив тусламжийн орлогыг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 "Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно", 44 дүгээр зүйлийн 44.1 "Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно", 44.1.1 "төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандив тусламжийн орлогыг бүртгэх, туслах үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг ТЕЗ-аас бичгээр авах талаар зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээн дэх асуудал нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн байдлаар дахин хянахад зөрчлийг арилгах 15,785.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмж хэрэгжээгүй 62.5 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	15,785.0	2	15,785.0	2		62.5
Нийт дүн	4	15,785.0	2	15,785.0	2		62.5

Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмж хэрэгжих шатандаа, өөрийн орлогын төлөвлөгөөг бодитой тооцож, төлөвлөж байх зөвлөмж хэрэгжээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлыг гүйцээн шалгаж амжаагүй тул ТЕЗ-ийн аудитаар авч үзэн үр дүнг аудитын тайланд нэгтгэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 420,918.7 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 38,828.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 196,193.8 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 185,896.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй 8 алдаа, зөрчлийн дүн 382,090.0 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 35,189.2 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 38,828.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн тайлангаарх машин тоног төхөөрөмжийн дүн дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 6,661.8 мянга, хуримтлагдсан элэгдэл 34,683.7 мянган төгрөгөөр;
- Санхүүгийн тайлангаарх тавилга эд хогшлын дүн дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 597.6 мянга, хуримтлагдсан элэгдэл 4,145.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн.

4.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн 196,193.8 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой дараах зөрчил илэрсэн.

- НДШ-ийн авлага 17,334.0 мянга, ХХОАТ-ын авлага 26,194.5 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.
- Олгохоор тооцсон цалинг НДШ-ийн тайланд 28,862.9 мянга, ХХОАТ-ын тайланд 70,477.0 мянган төгрөгөөр дутуу;
- Төлбөл зохих НДШ-ийг 17,049.2 мянга, ХХОАТ-ыг 5,318.2 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан;
- Албан хаагчдын гарт олгосон цалингийн дүн мөнгөн гүйлгээний журналаас 453.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илүү илэрхийлэгдсэн;
- Ажлын албаны 2021 оны 2 дугаар сарын цалинг давтан тооцоолоход нэр бүхий 1 албан хаагчид 52.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, ...", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын ... жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, олгохоор тооцсон цалинг үнэн зөв тооцож олгох, холбогдох тайлангуудыг бүрэн тайлагнах, төлбөл зохих НДШ, ХХОАТ-ыг нөхөн тайлагнах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Үндсэн хөрөнгө, бараа материалыг дэлгэрэнгүй бүртгэлээс түүвэрлэн жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй тулган шалгахад 30,451.9 мянган төгрөгийн хөрөнгө зөрүүтэй илэрхийлэгдсэн. Тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай хийж хэвших, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг батлагдсан загварын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5, 54.5.1, 54.5.2, 54.5.3, 54.5.4, 54.5.5, 54.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 8 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 3а "Төсвийн шууд захирагчийн мөнгөн орлого, зарлагад хийх тохируулгууд" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайланг бүрэн тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, төрийн аудитын байгууллагад ирүүлж байх талаар албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх оны аудитаар өгсөн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмж хэрэгжих шатандаа, өөрийн орлогын төлөвлөгөөг бодитой тооцож, төлөвлөж байх зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмыг Монгол Улсын ерөнхий аудитор батална", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл", 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Жилийн эцсийн байдлаар 16,971,029.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 180,370.2 мянган төгрөгийн бараа материалын тайлан бэлтгээгүй;
- Тавилга эд хогшлын дансанд эд хогшлын шинж чанаргүй дроз, ном, ариутгагч, хөшиг зэрэг 14 нэр төрлийн хөрөнгө, бусад хөрөнгөд гадаа камер, бумба зэрэг 4 төрлийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана", Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын НБББББ-ын 4.2.1 "Үндсэн хөрөнгө" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө бараа материалын тайлан бэлтгэх, хөрөнгийг ангиллын дагуу бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Нийт 15 дансны 868,981.3 мянган төгрөгийн 604 ажил гүйлгээнээс 760,736.8 мянган төгрөгийн 217 ажил гүйлгээг түүвэрлэн үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Багаж, техник хэрэгслийн зардлаас 70,663.7 сая төгрөгийн тавилга, эд хогшил бэлдсэн;
- Эдийн засгийн ангилал зөрчиж, 51,130.6 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан;
- Зарлагын гүйлгээг анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, цахим төлбөрийн баримтгүйгээр хийсэн;
- Байр ашиглалттай холбоотой зардлуудыг шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.7 "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримт болон цахим төлбөрийн баримтын бүрдлийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Нэмэлт төсвийн нийт 235,155.6 мянган төгрөгийн 68 ажил гүйлгээнээс 225,726.8 мянган төгрөгийн 20 ажил гүйлгээг түүвэрт хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ахмадын сувиллын төлбөрт 8,500.0 мянга, зочин төлөөлөгч хүлээн авахад 3,500.0 мянга, бэлэг дурсгалд 2,612.9 мянган төгрөгийг зарцуулсан, баримтын бүрдэл хангалгүйгээр 9,499.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан;
- Цахим төлбөрийн баримтгүйгээр 93,514.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараах арга

хэмжээнд зарцуулж болно. 46.3.1 "эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх", 46.3.2 "байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах", 46.3.3 "нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх", 46.3.4 "тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт хийх.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5 "Төлбөрийн баримт" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримт, цахим төлбөрийн баримт бүрдлийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Тээвэр шатахууны зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хэрэгцээнд нийт 17 автомашин ашиглагдаж байгаагаас 25 автомашинд 39,990.0 мянган төгрөгийн шатахуун олгосон бөгөөд автомашины шатахууны тооцоог жишиг нормыг баримталж хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 4 "Жолоочийн тооцооны хуудас", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Автомашинд олгосон шатахууныг Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормыг баримтлан сар бүр тооцоог бодох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Албан шаардлага, зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:							
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал														
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	АХГ-2022/360/НА-СТА-ТШЗ	1. НДШ-ийн авлага, ХХОАТ-ын авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Авлагыг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй. 2. Олгохоор тооцсон цалинг НДШ-ийн тайланд 28,862.9 мянга, ХХОАТ-ын тайланд 70,477.0 мянган төгрөгөөр дутуу; 3. Төлбөл зохих НДШ-ийг 17,049.2 мянга, ХХОАТ-ыг 5,318.2 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан; 4. Албан хаагчдын гарт олгосон цалингийн дүн мөнгөн гүйлгээний журналаас 453.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн; 5. Нэр бүхий 1 ажилтанд 52.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.	Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, олгохоор тооцсон цалинг үнэн зөв тооцож олгох, холбогдох тайлангуудыг бүрэн тайлагнах, төлбөл зохих НДШ, ХХОАТ-ыг нөхөн тайлагнах.	1	165,741.9					1	165,741.9		
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	АХГ-2022/360/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгө, бараа материалын дүн хөрөнгийн тооллогын бүртгэлээс 30,451.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй.	Хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай хийж хэвших, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах.	1	30,451.9					1	30,451.9		

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			хооронд гүйлгэн зарцуулсан; Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, цахим төлбөрийн баримтгүйгээр гүйлгээ хийсэн; Байр ашиглалттай холбоотой зардлуудыг шууд зардалд бүртгэсэн.	бүрдлийг хангаж ажиллах.														
7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	АХГ-2022/360/НА-СТА-ТШЗ	Нэмэлт төсвийн данснаас ахмадын сувиллын төлбөрт 8,500.0 мянган, зочин төлөөлөгч хүлээн авахад 3,500.0 мянга, бэлэг дурсгалд 2,612.9 мянган төгрөгийг зарцуулсан, баримт бүрдэл хангалтгүйгээр 9,499.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, цахим төлбөрийн баримтгүйгээр 93,514.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.	Нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримт, цахим төлбөрийн баримт бүрдлийг хангаж ажиллах.	1	24,111.9										1	24,111.9	
8	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	АХГ-2022/360/НА-СТА-ТШЗ	Автомашинны 39,990.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог жишиг нормын дагуу хийгээгүй.	Автомашинд олгосон шатахууныг Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормыг баримтлан тооцож байх.	1	39,990.0										1	39,990.0	
9	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	АХГ-2022/360/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл санхүүгийн тайлангийн дүнгээс 7,259.4 мянга, хуримтлагдсан элэгдэл	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл, элэгдлийг аудитын явцад залруулав.	1	38,828.7	1	38,828.7										0.0

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			38,828.7 төгрөгөөр илэрхийлэгдсэн.	мянган зерүүтэй												
			Дүн		9	420,918.7	1	38,828.7	0	0.0	4	196,193.8	0	0.0	4	185,896.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	АХГ- 2022/360/ НА-СТА- ТШЗ	ТЕЗ-аараа дамжуулалгүйгээр хандив тусламжийн орлогыг хүлээн авсан. Туслах үйл ажиллагаа явуулах талаар ТЕЗ-аас бичгээр зөвшөөрөл аваагүй.	Хандив тусламжийн орлогыг ТЕЗ- аараа дамжуулан бүртгэх, туслах үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг ТЕЗ-аас бичгээр авах.	1	0.0									1	0.0
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба	АХГ- 2022/360/ НА-СТА- ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд 2,930,735.5 мянган төгрөгийн 175 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах.	1	0.0									1	0.0
			Дүн		2	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	2	0.0
			Нийт дүн		11	420,918.7	1	38,828.7	0	0.0	4	196,193.8	0	0.0	6	185,896.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 177/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/360/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн байдлаар дахин хянахад авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хэрэгжих шатандаа, өөрийн орлогын төлөвлөгөөг бодитой тооцож, төлөвлөж байх зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмыг Монгол Улсын ерөнхий аудитор батална", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл", 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, ахлах нягтлан бодогч Г.Ариунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ц.ЭНХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 178/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/360/НА -СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг батлагдсан загварын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5, 54.5.1, 54.5.2, 54.5.3, 54.5.4, 54.5.5, 54.5.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 8 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-ын 3а "Төсвийн шууд захирагчийн мөнгөн орлого, зарлагад хийх тохируулгууд" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланг бүрэн тодруулгатай, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, төрийн аудитын байгууллагад ирүүлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, ахлах нягтлан бодогч Г.Ариунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-189.Docx

0010800613



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 179/А.0150058
АХГ-2022/360/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс түүвэрлэн жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй тулган шалгахад 30,451,946.00 төгрөгийн хөрөнгө зөрүүтэй илэрхийлэгдсэн. Тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийх, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, ахлах нягтлан бодогч Г.Ариунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109

90101020196

10.10.20 Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-188.Docx

0010800610



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 180/А0150058
АХГ-2022/360/МЬ-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 17,333,970.42 төгрөг, хувь хүний орлогын албан татварын авлага 26,194,496.52 төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.
2. Олгохоор тооцсон цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаар 28,862,872.00 төгрөг, хувь хүний орлогын албан татварын тайлангаар 70,477,041.00 төгрөгөөр дутуу;
3. Төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг 17,049,163.09 төгрөг, ХХОАТ-ыг 5,318,194.76 төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан;
4. Албан хаагчдын гарт олгосон цалингийн дүн мөнгөн гүйлгээний журналаас 453,169.59 төгрөгөөр зөрүүтэй илүү илэрхийлэгдсэн;
5. Ажлын албаны 2021 оны 2 дугаар сарын цалинг давтан тооцоолоход нэр бүхий 1 албан хаагчид 52,771.68 төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, ...", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын ... жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-187.Docx

0010800007

1. Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, олгохоор тооцсон цалинг үнэн зөв тооцож олгох, холбогдох тайлангуудыг бүрэн тайлагнах, төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг нөхөн тайлагнаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, ахлах нягтлан бодогч Г.Ариунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ц.ЭНХЖАРГАЛ

